

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2008 оны 12 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 274

Улаанбаатар хот

“Мөнгөн цэгц” ХХК-д валют солих цэгийн
үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 91 дүгээр тогтоолоор баталсан “Валют солих цэг ажиллуулах журам”-ын 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Мөнгөн цэгц” ХХК-д валют солих цэгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Мөнгөн цэгц” ХХК /Д.Баттулга/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ